



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 617

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 10,286,593,133.00 (арван тэрбум хоёр зуун наян зургаан сая таван зуун ерэн гурван мянга нэг зуун гучин гурав) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Говь-Алтай, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, эзэмшигчийг тогтоож бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002681

28-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын 21-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Говь-Алтай аймгийн зоонозын өвчин- судлалын төвийн барилга (Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай барилга, дунд төвөгшилтэй, зoorьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 30.09*14.70м, (гадна цахилгаанны шугам, цэвэр бохир усны, дулааны шугам, холбооны кабель, дизель генератор, тоног төхөөрөмж, явган зам, хашаа, авто зогсоолын талбай)	4,377,799,978.00	2024.07.31	ББКД-82-00006/24	Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газар, Говь-Алтай аймгийн зоонозын өвчин судлалын төв
2	Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга (хэнтий аймаг, Бор-Өндөр сум, Эмнэлгийн өргөтгөлийн барилга, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төвөгшилтэй, зoorьтой, 1 давхар, тэнхлэгээрээ 42.5м*18.0м өргөтгөлийн барилга (гадна цахилгааны шугам, гадна цэвэр бохир усны шугам, явган болон авто зам, дулааны шугам, дэд өртөөний тоноглол, дизель генератор, лифт)	5,908,793,155.00	2024.09.03	БУ-33/2024	Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэг
НИЙТ ДҮН			10,286,593,133.00 (арван тэрбум хоёр зуун наян зургаан сая таван зуун ерэн гурван мянга нэг зуун гучин гурав)			